

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Булган-Ундрага ХК-ийн ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурал 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдөр live.ard.mn цахим хуудсаар дамжуулан 11:00 цагаас эхлэв.

Хурлыг нээж хурлын дарга Ч.Ганхуяг хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, талархал илэрхийллээ. Хурлын тооллогын комиссоор Өмгөөллийн Сноу-Хилл хуулийн фирмийн хуульч Номин-Эрдэнэ, Намжилмаа, Оюун-Эрдэнэ нар болон Ард Менежмент ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Хандаа, Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г. Мягмаржав, Ард Бит ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Чадраабал болон Ард Менежмент ҮЦК ХХК-ийн бусад ажилчдын бүрэлдэхүүн оролцож байгааг танилцуулав.

ТУЗ-ын гишүүн А.Тулга хувьцаа эзэмшигчдэд хуралд нь амжилт хүсэн үг хэлэв. Мөн Ард Бит ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Чадраабал нь хувьцаа эзэмшигч нарт крипто зах зээлийн сүүлийн үеийн мэдээллийг хүргэлээ. Харин Булган-Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав нь хувьцаа эзэмшигч нарт ТУЗ-ын талаар танилцуулан, хувьцаа эзэмшигчийн хурлын бүртгэлтэй холбоотой тайлбарыг хийлээ.

Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга С.Намжилмааг хурлын ирцийг танилцуулахыг урив.

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга С.Намжилмаа

Хурлын ирц 07 дугаар сарын 12-ны өдөр буюу бүртгэлийн өдрөөр нийт 113,212 саналын эрхтэй хувьцаа байгаагаас 80,721 буюу 71.3%-ийн ирцтэйгээр Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн ээлжит бус хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай хурлын дарга Ч.Ганхуягт мэдэгдэж, хурлыг нээв.

Танилцуулсан: Хурлын дарга Ч.Ганхуяг

Ирц бүрдлээ. ТУЗ-аас надад оногдуулсан үүргийн дагуу энэ хурлыг эхэлсэнд тооцё. Ингээд би түрүүн хуралд оролцож байгаа танилцуулга хийх хүмүүсийг танилцуулсан. ТУЗ-ын гишүүдээс бол А.Тулга, Б.Золбоо, Г.Мягмаржав, Ч.Ганхуяг, Ч.Хандаа гэсэн хүмүүс хуралд оролцож байна. Бусад хүмүүс фэйсбүүк лайваар хурлаа үзэж байгаа байх. Ингээд хэлэлцэх асуудалдаа орё. Хурлын дэгийн дагуу бүртгэлээ хийлгээд кодоороо ороод хэлэлцэж буй асуудлууд дээр санааа өгнө. Өнөөдөр хэлэлцэх асуудалд

1. Компанийн оноосон нэрийг Крипто Үндэстэн ХК болгон өөрчлөх
2. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгох
3. Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулж ирж байна.

Танилцуулсан: Булган-Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав:

Гүйцэтгэх удирдлага Г.Мягмаржав өөрийгөө товч танилцуулжэнэ 8 сараас эхлэн Булган-Ундрага буюу Кripto-Үндэстэн компанийнхаа гүйцэтгэх захирлаар томилогдоод ажиллаж байгаагаа дурдав.. Мөн тэрээр Булган-Ундрага ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Компанийн хагас жилийн санхүүгийн тайланг харвал: 26.8 тэрбум төгрөгний хөрөнгөтэй, 2.2 тэрбум төгрөгийн өр төлбөр, 24.6 тэрбум төгрөгийн эзний өмчтэй байна. Орлогын тайлангаас үзвэл 20 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Харин хувьцаа эзэмшигчдийн бүтэц маань хагас жилээр нийт 877 хувьцаа эзэмшигчидтэй байна.

Хэлэлцсэн нь №1:

Компанийн оноосон нэрийг Кripto Үндэстэн ХК болгон өөрчлөх

Танилцуулсан: Булган-Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Эхний хэлэлцэх асуудал маань бол “Компанийн оноосон нэрийг Кripto Үндэстэн ХК болгон өөрчлөх” асуудал байна. Компанийн нэрийг Булган- Ундрага ХК-иасКripto Үндэстэн ХК болгож өөрчлөх асуудлаар санал авхаар байна .

Танилцуулсан: Хурлын дарга Ч.Ганхуяг

Булган- Ундрага ХК-ийн нэрийг өөрчлөн Кripto Үндэстэн ХК болгох, шийдвэр гаргахаар байгаа. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид уг асуудлыг дэмжиж байвал саналаа өгөөрөй. Санал хураах ажил, саналыг тоолох ажлыг манай тооллогын комисс гүйцэтгэх болно. Миний бодож байгаагаар бол цөмөөрөө бүх хэлэлцэх асуудал, шийдвэр гаргах асуудлуудаа танилцуулаад санал хураах хуудсаа нээгээд, тэр хооронд нь цөмөөрөө хувьцаа эзэмшигчид нараасаа асуултууд байвал хариулаад явах нь зөв байх.

Хэлэлцсэн нь №2:

Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцөлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгох

Танилцуулсан: Хурлын дарга Ч.Ганхуяг

Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцөлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгох асуудлыг хэлэлцэн санал өгнө. Нэмж хувьцаа гаргажкомпанийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, багцаа төрөлжүүлэх, нэмэгдүүлэх ажлыг хийнэ гэж төлөвлөж байна. Та бүхэн уг асуудалтай холбоотойгоор саналаа өгөөрэй гэж хүсье.

Хэлэлцсэн нь №3:

Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх

Танилцуулсан: Хурлын дарга Ч.Ганхуяг

Уг асуудал дээр манай хувьцаа эзэмшигчид өөрсдөө гаргах гэж буй хувьцаагаа тэргүүн ээлжид худалдаж авах эрхтэй байх нь зөв зүйтэй гэж харж байна. Энэ нь дээр компанийн зүгээс, удирдлагын зүгээс ТУЗ-ын зүгээс ямар байр суурьтай, энэ асуудлыг дэмжих юм уу, хувьцаа эзэмшигчдийгээ битгий дэмжээрэй гэж хүсч байгаа юм уу. Шууд зах зээл дээр гаргая гэж байгаа юм уу Хандаа.

Танилцуулсан нь: Ард Менежмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Хандаа

Өнгөрсөн 4 сарын 28-нд Булган-Ундрага ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болсон. Уг хурлаар ТУЗ-ыхаа гишүүдийг сонгосон. ТУЗ-ын гишүүд компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах, үр ашигтай явуулах чиглэлээр 2-3 удаа хуралдсан байна. Компанийн хувьд ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчдэдээ тэргүүн ээлжид хувьцаа авах эрхийг нээж өгөх хэрэгтэй, Хувьцааны тоо 113,212 байгаа, тэгээд 1,000,000 ширхэг зарласан хувьцаатай байя, хувьцаагаа гаргах хэмжээ, хэлбэр зэргийг зах зээлийнхээ нөхцөл байдлыг харж байгаад ТУЗ-аас шийдвэрүүдээ гаргаад явах байх. Тэгээд ТУЗ-ын зүгээс хувьцаа эзэмшигчдэдээ тэргүүн ээлжид худалдаж авах эрхийг нь хэрэгжүүлбэ, гэхдээ бас тодорхой хэмжээний зах зээлийн үнэлгээнээс хямдруулж өгөх үү гэдгийг тухайн үедээ шийдээд хувьцаа эзэмшигчдэдээ мэдэгдэнэ гэж ярьсан байгаа. Хувьцаа эзэмшигчид маань хувьцаагаа тэргүүн ээлжид худалдаж авах сонирхолтой бол зөвшөөрсөн гэсэн саналыг, тэргүүн ээлжид худалдаж авах сонирхолгүй бол татгалзсан түдгэлзсэн гэдгийг тэмдэглээд явах боломжтой байгаа.

Хэлэлцсэн нь №4:

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

Танилцуулсан: Булган-Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Компанийн журамд дээрх хэлэлцсэн асуудалтай холбоотой өөрчлөлтүүдийг оруулж дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах дээр нийт хувьцаа эзэмшигчид маань саналаа өгч байгаа байх.

Танилцуулсан: Хурлын дарга Ч.Ганхуяг

Санал хураах ажиллагаа эхэлж байна. Компанийн оноосон нэрийг Кripto Үндэстэн ХК болгон өөрчлөх, компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцөлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгох, компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах гэсэн 4 асуудалд саналаа хурааж байна. Саналаа өгөөрэй.

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга С.Намжилмаа

Санал хураалт явж байна. 11:55 гээд санал хураалтыг зогсоож, та бүхэндээ зарлах болно. Одоогоор санал хураалтын явц 90%-тай явж байна..

Асуулт. Булган-Ундрага компанийн 1 ширхэг хувьцааг 200,000 хэдэн мянгаар тооцож авсан хүмүүс яах вэ?

Хариулт. Хурлын дарга Ч.Ганхуяг: Та бүхэн маань 200,000 хэдэн мянгаас дээш болохыг хүлээгээрэй

Асуулт. Хувьцаагаа хуваах уу?

Хариулт. Хурлын дарга Ч.Ганхуяг: Үнэтэй байвал бид нар хувьцаагаа хувааж болно. Бид энэ талаар судалж та бүхэндээ цаг тухай бүрт нь мэдээлэл хүргэх болно.

Асуулт, хариулт дуусав.

Санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга С.Намжилмаа: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн оноосон нэрийг Кристо Үндэстэн ХК болгон өөрчлөх асуудлыг хэлэлцэн батлах тухай санал хураалтад нийт 80,721 ширхэг хувьцаа буюу 71.3%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1 Зөвшөөрсөн- 80,548 ширхэг буюу 99.785%
 - 1.2 Татгалзсан-1 ширхэг буюу 0.0012%
 - 1.3 Түдгэлзсэн-Байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцөлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай санал хураалтад 80,721 ширхэг хувьцаа буюу 71.3%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 2.1.Зөвшөөрсөн- 80,547 ширхэг буюу 99.784%
 - 2.2. Татгалзсан-2 ширхэг буюу 0.0024%
 - 2.3.Түдгэлзсэн-Байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
3. Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх тухай санал хураалтын дүн:
 - 3.1.Зөвшөөрсөн- 80,548 ширхэг буюу 99.785%
 - 3.2. Татгалзсан-байхгүй.
 - 3.3.Түдгэлзсэн-1 ширхэг буюу 0.0012% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай санал хураалтын дүн:
 - 4.1.Зөвшөөрсөн- 80,549 ширхэг буюу 99.786%
 - 4.2. Татгалзсан- байхгүй

4.3.Түдгэлзсэн-байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хурлын дарга Ч.Ганхуяг хурлыг хаан үг хэлэв.

Хурал 12 цаг 00 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Ч.ГАНХУЯГ

Ч.ХАНДСҮРЭН